



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 25 өдөр

Дугаар A/167

Булган

**Гүйцэтгэгчтэй гэрээ шууд
байгуулах тухай**

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Засгийн газрын "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 2018 оны 129 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Сэлэнгэ сумын Сэлэнгэ мөрний эргийн бэхэлгээний ажлын инженер геологийн судалгааны ажлыг 9000000 /есөн сая/ төгрөгөөр "Барнаб" ХХК-тай гэрээ шууд байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлыг холбогдох норм, дүрмийн шаардлагын түвшинд магадлалд оруулан гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Барнаб" ХХК /Ц.Ганхөлөг/-д даалгасугай.

3. Дээрх инженер геологийн судалгааны үнийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны ээлжит X хуралдааны 10/07 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 22 дугаар /Эргийн бэхэлгээний ажлын зураг төсөв боловсруулах/-т тусгагдсан төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Д.Батцогт/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ